



Улаанбаатар телевиз



БОЛОВСРОЛ,
СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ




Посольство
Российской Федерации
в Монголии



Российский центр
науки и культуры в
Улан-Баторе

ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ: ОХУ-ын ЭСЯ, БСШУЯ-ны дэмжлэгтэйгээр Оросын шинжлэх ухаан соёлын төв (РЦНК)



РОССИЙСКАЯ
ОБРАЗОВАТЕЛЬНАЯ
ВЫСТАВКА




ОРОСЫН БОЛОВСРОЛЫН ҮЗЭСГЭЛЭН EXPO 2016 03.17-19

РОССИЙСКАЯ ОБРАЗОВАТЕЛЬНАЯ ВЫСТАВКА 2016



2016.03.17-19

Эрхэм хүндэт Монголын оюутан, сурагч, залуучууд аа!



Орос-монголын боловсролын салбар дахь хамтын ажиллагаа нь тэртээх 1922 оноос монголын анхны 15 охид, хөвгүүд Орос Улсын их дээд сургуульд суралцсанаар эхэлсэн юм. Тэгвэл өнөөдрийн байдлаар 60 000 гаруй монголчууд Зөвлөлт болон Оросын их дээд сургуулиудыг төгсөж тэдний дундаас Монгол Улсын дөрвөн ерөнхийлөгч, сансрын нисгэгч Гүррагчаа гээд олон улс төр нийгмийн зүтгэлтнүүд, урлаг, спорт, бизнесийн салбарынхан, эрдэмтэд, зохиолчид төрөн гарсан байдаг.

Тэгвэл энэхүү сайхан уламжлалаа үргэлжлүүлэхээр бид “Оросын боловсролын үзэсгэлэн EXPO-2016” арга хэмжээг Монголд анх удаагаа зохион байгуулж, Монголын хүүхэд залуучууддаа оюуны хөрөнгө оруулалт хийхээр зорьж байна. Энэ үүднээс Та бүхэнд дэлхийн боловсролыг хөрш орондоо эзэмшихийг санал болгохоор Оросын шилдэг их дээд сургуулиудын төлөөлөгчид Москва, Владивосток, Красноярск, Кемерово, Томск, Иркутск, Якутск, Свердловск, Белгород, Буриадаас хүрэлцэн ирээд байна.

Үүний зэрэгцээ ОХУ-ын засгийн газраас жил бүр дээд боловсролын тэтгэлэгт хөтөлбөрүүдийг зарладаг бөгөөд энэ жил Монгол Улсад зориулан 376 хуваарь санал болгож байгаа. Хэрэв Та бүхэн тэтгэлэгт хамрагдахыг хүсвэл үзэсгэлэнгийн үеэр бүртгүүлж, сонгон шалгаруулалтандаа нээлттэй, ил тод байдлаар оролцон, сонирхсон мэргэжил, мэргэшлээ сонгон суралцахыг урьж байна.

Та бүхний сонголт мэргэн, ирээдүй тань гэгээлэг байх болтугай!

Е.Г.Михайлов

*ОХУ-ын Монгол Улс дахь ЭСЯ-ны Зөвлөх,
Россотрудничество агентлагийн Монгол дахь төлөөлөгчийн газрын тэргүүн,
Оросын шинжлэх ухаан соёлын төвийн захирал*

2016/2017 оны хичээлийн
жилүүдэд ОХУ-ын их дээд
сургуулиудад тэтгэлгээр
суралцахыг хүсэгчид:

<http://mng.rs.gov.ru/>,
<http://минобрнауки.рф/>,
<http://rs.gov.ru/>,
<http://obrnadzor.gov.ru/> сайтаар бүртгүүлнэ үү.



Vladivostok State University
Economics and Service

ВЛАДИВОСТОКИЙН ЭДИЙН ЗАСАГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ



ВЭЗУУИС бол ОХУ-ын төр засгийн түвшний төрөл бүрийн шагнал, урамшуулал, тэтгэлгээр батлагдах Алс Дорнодын тэргүүн эгнээний орчин үеийн их сургуулиудын нэг юм. ВЭЗШУИС нь дээд боловсрол эзэмшээд хаана ч эрэлтэй мэргэжилтэн болох боломжийг олгодог. Тус их сургууль нь сургалтын нийгмийн асуудлыг бүрэн хэмжээнд нь хангадаг бөгөөд ВЭЗУУИС-ийн материаллаг баазад сургалтын байрууд, оюутны байр, номын сан, спорт амралтын цогцолборууд орох ба эдгээр нь хөгжил дэвшил, нийгмийн эрэлт хэрэгцээнд бүрэн нийцсэн байдаг.

ВЭЗУУИС нь В.Потанины нэрэмжит буяны сангийн рейтингэд Алс Дорнодын их сургуулиуд дундаас үргэлж 1-р байранд орж, Урал хүртэлх нутаг дэвсгэр дээр хамгийн сайн их сургууль гэдгээ баталсаар байна. Мөн "Их сургуулиудын элсэлтийн чанар" хэмээх нийт Оросын рейтингээр

хэлмэрч-орчуулагч, менежер, удирдах ажилтнуудыг бэлтгэж чадсанаараа үнэлэгдсэн юм.

Их сургуулийн оюутны байр нь дэлхийн шилдэг жишгээр зохион байгуулагдсан ба үүнд сургалтын болон амьдрах байрууд, спорт, эрүүл мэнд,

эрхлэх, бүтээлчээр эрүүл амьдралын хэв маягийг баримтлах бүхий л орчин бүрдсэн байдаг.

Одоогийн байдлаар ВЭЗУУИС-д гадаадын Армен, Украин, Гүрж, Киргиз, Молдов, Азербайджан, Хятад, Япон, Вьетнам, БНСУ, Лаос, Нигер зэрэг 12 орноос 600 гаруй гадаад оюутан суралцаж байна. ВЭЗУУИС-ийн гадаад оюутнуудын дунд орос хэлний сонсогчид байдаг бөгөөд тэдний газар зүйн харъяалал нь арай өргөн Филиппин, Индонез, Чех, БНАСАУ-ын иргэд байдаг. Бүх гадаад оюутнууд их сургуулийн кампуст орших дотуур байранд амьдардаг.

Владивостокийн эдийн засаг үйлчилгээний улсын их сургууль нь та бүхнийг манайд суралцахыг урьж байна! Сургалтын төлбөр нь эзэмших мэргэжлээс хамаарах бөгөөд өдрөөр сурах тохиолдолд 108000-аас 230000 рублийн хооронд байдаг.



525 Приморскийн их сургуулиудыг ардаа орхин тэргүүлсэн юм. ВЭЗУУИС-ийн бас нэгэн амжилт бол Сочигийн олимпийн сайн дурын ажилтнуудыг бэлтгэх Төвийг нээх уралдаанд түрүүлсэн явдал бөгөөд ВЭЗУУИС нь оюутнуудын сайн дурын хөдөлгөөний үр дүнтэй ажлын түүх, өндөр түвшний

амрах цогцолборууд кафе, дэлгүүр, үйлчилгээний алба нь бүгд нэгэн дээвэр доор, камерын хяналттайгаар, олон нийтэд нээлттэйгээр төвлөгрөг. Оюутнуудад сургалт, аж ахуй

ХОЛБОГДОХ ХАЯГ:

Хаяг: ОХУ, Владивосток хот, Гоголийн 41гүд.
Утас: 8(423) 240-41-38 (олон улсын боловсролын хөтөлбөрийн хэлтэсийн дарга - Кравченко Юлия Сергеевна)
E-mail: yuliya.kravchenko@vvsu.ru, international@vvsu.ru
Вэбсайт: <http://www.vvsu.ru/>, <http://eng.vvsu.ru/>



В.Я.ГОРИНЫ НЭРЭМЖИТ БЕЛГОРОДЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛЬ

УЛАМЖЛАЛ, ЧАНАР, ИРЭЭДҮЙН БОЛОМЖУУД!

БХААИС нь ОХУ-аас гадна гадаадад нэр хүндтэй бүсийн томоохон сургалт, шинжлэх ухаан, үйлдвэрлэл хосолсон хөдөө аж ахуйн цогцолбор юм. Тус их сургууль нь шинэ үеийн инновацийг чиглэсэн баялаг материаллаг бааз болон өндөр мэргэжлийн боловсон хүчинтэй. БХААИС нь Оросод анх удаа ажил олгогчийн шаардлагыг хангахад чиглэсэн, төгсөгчдийн мэргэжлийн карьераа амжилттай эхлүүлэх боломжийг олгосон хос мэргэжлийн сургалт нэвтрүүлж эхэлсэн.

Манай их сургууль нь өргөн хүрээнд бүтээлчээр сэтгэх чадвартай, алсын хараатайгаар урьдчилан харах, төлөвлөх ухаантай 21000 мэргэжилтэн бэлтгээд байна. Их сургуулийн төгсөгчдийн дунд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх чиглэлийн томоохон аж ахуйн удирдлага, ахлах мэргэжилтэн багагүй байгаагаас гадна төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, шинжлэх ухаан, судалгааны чиглэлийн боловсон хүчнүүд ихээхэн байдаг.

**АЖЛЫН
БАЙРНЫ ЗАХ
ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ
ХЭРЭГЦЭЭНД
НИЙЦСЭН ДЭЭД
БОЛОВСРОЛ,
МЭРГЭЖИЛ
ЭЗЭМШИХ
БОЛОМЖ!**



Бакалавр, магистрын хөтөлбөрийн сургалтууд нь 6 факультетад явагддаг. Үүнд: хөдөө аж ахуйн, малын анагаах ухааны, инженерийн, технологийн (зоотехник, болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулалт), эдийн засгийн, эчнээ сургалтын факультетууд багтдаг. Мөн их сургуулийн тусгай дунд боловсролын факультетад (коллеж) мэргэжил эзэмших боломжтой.

Сургалт нь 7 хоногийн 5 өдөр 1 ээлжинд явагддаг. Бүх оюутнууд тохилог оюутны байруудад амьдардаг.

БИЧИГ БАРИМТ ХҮЛЭЭН АВАХ:

- Эчнээгээр сурах – 2016 оны 2 сарын 1 – 8 сарын 10 өдрүүдэд
- Өдрөөр сурах – 2016 оны 7 сарын 15 – 6 сарын 17 өдрүүдэд

Бичиг баримтууд: (эх хувь эсвэл хуулбар):

- Оргөдөл; иргэний үнэмлэх; боловсролын байдлыг илэрхийлэх бичиг баримт;
- 3x4 хэмжээтэй 6 хувь зураг (дотоод шалгалтанд орж буй хүмүүст);
- 086У хэлбэрийн эрүүл мэндийн хуудас

- Лицензийн рег.№1291 от 25.02.2015, дугаар 90Л01 №0008277,
- Улсын боловсрол, шинжлэх ухааны хяналтын албанаас хугацаагүйгээр олгов.
- Аттестатчилалын гэрчилгээний рег.№ 0587 от 24.04.2013, дугаар 90А01 № 0000591,
- Оросын боловсролын хяналтын албанаас олгов, 2019.04.24-нийг хүртэл хүчинтэй

ХОЛБОГДОХ ХАЯГ:

308503 Белгород муж,
Белгород дүүрэг, Майский
тосгон, Вавилова гуд., 1
Утас: +7 (4722) 381346, +7
(4722)39-11-74,

+7 9038870870 (Свищева
Ирина Викторовна)

E-mail: bsaa-inter2@mail.ru
(Свищева Ирина Викторовна)
bsaa_z@mail.ru (Загорюлько
Елена Владимировна)

Вэбсайт: www.bsaa.edu.ru



Г.В.ПЛЕХАНОВЫН НЭРЭМЖИТ ОРОСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ

100 жилийн түүхтэй Г.В.Плекхановын нэрэмжит Оросын эдийн засгийн их сургууль нь ОХУ-ын шилдэг эдийн засгийн их сургуульд зүй ёсоор тооцогддог. Улсынхаа шинжлэх ухаан болон оюуны өндөр боловсролтой иргэдээ төлөвшүүлэхдээ тус их сургууль нь оюутан аспирантууддаа эдийн засаг, бараа судлал, технолог, хууль зүйн чиглэлээр чанартай боловсрол санал болгодог.

Г.В.Плекхановын нэрэмжит Оросын эдийн засгийн их сургуулийн төгсөгчидийн ихэнх нь эдийн засгийн салбарын тэргүүлэх эгнээнд явж, гадаад дотоодын төрийн болон хувийн хэвшлийн шилдэг байгууллагуудад ажиллаж байна.



Г.В.Плекхановын нэрэмжит Оросын эдийн засгийн их сургууль нь өнөөдрийн байдлаар:

- Өндөр үр чадвартай мэргэжилтэн бэлтгэх хамгийн том боловсролын төв
- 64000 оюутан сурч байна
- Их сургуульд хэрэгжүүлж байгаа боловсролын хөтөлбөрүүдийн тоо нь 90 гараад байгаа бөгөөд үүнд 45 орчим бакалаврын, 30 мэргэжлийн, 15 магистрын чиглэлээр сургаж байна.
- Их сургуулийн бүтцэд Орос болон гадаадад байрлалтай 46 салбар багтдаг.
- Боловсрол: англи хэл дээрх хичээлийн тоог нэмэгдүүлэн 2 хэл дээр сургалтаа явуулж байна (2014: бакалаврын 2 бүтэн, 4 хэсэгчилсэн хөтөлбөр, магистрын 5 бүтэн, 16 хэсэгчилсэн хөтөлбөр)
- Сургалт болон шинжлэх ухааны үйл ажиллагаанд гадаадын багш, мэргэжилтэн, эрдэмтэд өргөнөөр хамрагддаг

Г.В.Плекхановын нэрэмжит Оросын эдийн засгийн их сургуулийн боломжууд

Олон улсын хамтарсан боловсролын хөтөлбөрүүдийн хүрээнд Оросын эдийн засгийн их сургуулийн оюутнууд 2 эсвэл 3 дипломтой төгсөх боломжтой байдаг. Уг төсөлд Франц, Герман, Нидерланд, Австри зэрэг 14 орноос оролцож байна.

Г.В.Плекхановын нэрэмжит Оросын эдийн засгийн их сургуулийн гол зорилго

Ирээдүйд Оросын болон дэлхийн мэргэжилтнүүдийн нийгэмд тэргүүлэх өндөр үр чадвартай лидер боловсон хүчнүүдийг хариуцлага, үр дүнтэйгээр бэлтгэхэд оршино.

Г.В.Плекхановын нэрэмжит Оросын эдийн засгийн их сургуулийн Улаанбаатар дахь салбар

Улаанбаатарын салбар нь Монгол дахь Оросын цогц боловсролын салбар бөгөөд үүнд оросын боловсролын стандартаар орос хэл дээр хичээл ордог. Төгсөгчдөд Оросын диплом болон аттестат олгогддог. Уг салбар нь плекхановын шилдэг боловсролын уламжлалаа Монголд амжилттай үргэлжлүүлсээр байна.

ХОЛБОГДОХ ХАЯГ:

Монгол Улс, Улаанбаатар хот, БЗД, Энх тайвны гудамж, 131 байр
Утас: (976) 11-450679
E-mail: ubfil@mongol.net
Вэбсайт: www.rea.mn



И.М.ГУБКИНЫ НЭРЭМЖИТ ОХУ-ЫН НЕФТЬ ГАЗЫН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

И.М.Губкины нэрэмжит ОХУ-ын нефть газрын улсын их сургууль нь (үндэсний судалгааны их сургууль) ОХУ-ын нефть газрын салбарын хамгийн том дээд боловсролын байгууллага бөгөөд, бүх түвшний мэргэжилтнүүдийг бэлтгэдэг шилдэг сургалт, шинжлэх ухаан хосолсон цогцолбор төв юм.



И.М.Губкины нэрэмжит ОХУ-ын нефть газрын улсын их сургууль нь нефть газрын бүх салбарын бакалавр, мэргэжилтэн, магистр, аспирантурын хөтөлбөрөөр бэлтгэдэг. Үүнд: нефть газрын геолог, геофизик, нүүрс-устөрөгчийн орд газрын ашиглалт, ерөмдлөг, нүүрс-устөрөгчийн боловсруулалт, тээвэрлэлт, нефть газрын үйлдвэрлэлийн машин тоног төхөөрөмж, автоматик компьютерийн загварчлал, байгаль орчны хамгаалал, нефть газрын байгууллагуудын эдийн засаг, менежмент, хууль зүйн мэргэжлүүдээр тус тус сургадаг.

Их сургууль нь 1947 оноос гадаад орнуудын мэргэжилтнүүдийг бэлтгэж, одоогийн байдлаар 124 орны 6969 мэргэжилтэн, үүнээс 675 докторант, 12 доктор төгсгөөд байна.

Манай их сургуулийн гадаад төгсөгчдийн дунд нефть

газын компаниудын захирлууд, их дээд сургуулиудын ректорууд болон дэд ректорууд, шинжлэх ухаан судалгааны институтуудын захирлууд, нефть газрын шинжлэх ухааны шилдэг эрдэмтэд, нефть газрын яамдуудын удирдлагууд, дипломауд ихээхэн байдаг.

Өнөөгийн байдлаар манай сургуульд 50 орноос 1593 гадаад оюутан суралцаж байгаагаас 652 оюутан нь Ташкент хот дахь И.М.Губкины нэрэмжит ОХУ-ын нефть газрын улсын их сургуулийн салбар сургуульд сурч байна.

И.М.Губкины нэрэмжит ОХУ-ын нефть газрын улсын их сургууль нь олон жилийн хугацаанд Монгол Улсын нефть газрын салбарын инженерийн боловсон хүчнийг бэлтгэж байгаагаас 129 мэргэжилтэн, 6 докторант төгсгөсөн байна.



ХОЛБОГДОХ ХАЯГ:

Хаяг: 119991, ОХУ, Москва хот, Ленинский өргөн чөлөө, 65 байр, 1-р корпус

Утас: +7(499) 507 81 29

Факс: +7(499) 507-88-77

E-mail: dis@gubkin.ru

Web-site: www.gubkin.ru

КЕМЕРОВЫН ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ



Ирээдүйн оюутнууд аа Та бүхэнд мэндчилж байна!
Та бүхнийг манай сургуульд суралцахыг урьж байна!
Манай сургууль нь Кузбассын их сургуулиудын рейтингэд хамгийн дээгүүрт жагсдаг!
Бид ОХУ-ын шилдэг техникийн 100 сургуульд багтдаг!
КХУТИС бол хүнсний салбарт мэргэжилтэн бэлтгэдэг Оросдоо цорын ганц их сургууль юм! Манай сургууль мөн тэтгэлгээр сургадаг!



КХУТИС нь өөрийн байгуулагдсан үеэс хойш олон салбарт боловсролын цогцолбор болтлоо өсч хөгжин, техник, технолог, эдийн засаг, удирдлагын чиглэлүүдээр чанартай боловсон хүчнийг бэлтгээд байна.

Өнөөдөр бол тус сургууль нь ТУХН-ийн орнууд, Урал, Алс Дорнод, Сибирийн хүнсний үйлдвэрлэлийн болон бусад үйлдвэрлэлийн чиглэлийн байгууллагуудын боловсон хүчнүүдийг бэлтгэх тэргүүн зэргийн төв нь болоод байна. Кузбассын их дээд сургуулиудын шилдэгүүдийн нэгэнд тооцогдох КХУТИС нь Оросын түвшинд өндөр байр суурь эзлэж байгаагаа харуулсаар байгаа.

Их сургууль нь олон тооны ажилтан албан хаагчидтайгаас багш нарын тоо гэхэд 450 бөгөөд эдгээрээс зэрэг цолтой нь 70%-ийг эзэлдэг. Манай их сургуульд ажилладаг 13 профессор ОХУ-ын болоод олон улсын нийгэм, мэргэжлийн чиглэлийн академийн гишүүд байдаг. Мөн ОХУ-ын шинжлэх ухаан, техник, бусад салбарын гавьяат багш нар бий. Түүнээс гадна "Дээд боловсролын тэргүүний ажилтан", "Дээд боловсролын байгууллагын тэргүүний ажилтан", "Хүндэт химич" цол тэмлэгтэй ажилтнууд цөөнгүй байгаа.

КХУТИС-ын материаллаг бааз нь байнгын нэмэгдэж шинэчлэгдэж байдаг. Өнөөгийн байдлаар их сургууль нь компьютерийн шинэ

техникийн парк, 5 сургалтын байр, шинжлэх ухаан техникийн номын сан, хоолны газар, кафе, спорт цогцолбор, 4 зочид буудлын хэлбэрээр тохижуулсан оюутны дотуур байртай. Мөн 1-р оюутны байранд эрүүл мэндийн төв ажилладаг бөгөөд энд оюутнууд,



аспирантуудын эрүүл мэндийн байдлыг үзүүлж, анхны түргэн тусламж үзүүлдэг. 2-р оюутны байрны 9 давхарт "Юность" сувиллын газар үйл ажиллагаагаа явуулдаг. Дотуур байрууд нь бүгд интернэтэд холбогдсон.

КХУТИС нь мэргэжилтэн бэлтгэхдээ бүх төрлийн дадлагын ажлуудад ихээхэн анхаарлаа хандуулдаг. Үйлдвэрлэлийн дадлага хийхээр оюутнууд Сибирийн бүс нутгийн бүхий л үйлдвэр аж ахуйн нэгжүүд болон түүнээс гадна Москва, Санкт-Петербургэд хүртэл ажилладаг.

КХУТИС-ЫН ЭЛСЭЛТИЙН КОМИСС:

Кемерово, 6-р Строителей 47,
ауд. 1100
Утас: +7(3842)73-23-12 ;
факс: +7(3842)73-23-12; тел.:
8-800-500-71-41 (үнэгүй)
e-mail: pk@kemtipp.ru.
Вэбсайт: www.kemtipp.ru



КРАСНОЯРСКИЙ ХӨДӨӨ АЖ АХУЙН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Красноярский хөдөө аж ахуйн улсын их сургууль бол хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, эдийн засаг, менежмент болон хуулийн чиглэлээр дээд, дунд боловсролын хөтөлбөрүүдийн дагуу өндөр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэдэг орчин үеийн боловсролын төв юм.

Өнөөдрийн байдлаар Красноярскийн хөдөө аж ахуйн улсын их сургууль нь Сибирийн нутаг дэвсгэр дээрх томоохон сургуулиудын нэгд зүй ёсоор тооцогддог бөгөөд мэргэжилтнүүдийг чанарын өндөр түвшинд бэлтгэх бүхий л шаардлагатай материал техникийн баазаар хангагдсан. 14000 гаруй оюутнууд бакалаврын 23, магистрын 8, дунд боловсролын 5 мэргэжлийн чиглэлээр суралцаж байна.

Оюутнууд нь ОХУ-ын бүхий л мужуудын орос иргэд байхаас гадна мөн гадаадын иргэд ч байдаг.

Сургуулийн хэрэгжүүлж буй заах арга барил нь гадаад улсуудын иргэд их сургуулийн орчинд амархан дасах, орос хэлийг сайн сурах бүхий л боломжийг олгодог.

Боловсролын үйл ажиллагаа явуулах эрх нь их сургуулийн лиценз, улсын аттестатчилалд хамрагдсанаар баталгааждаг. Эзэмшсэн боловсролын чанар нь ОХУ-ын болон олон улсын менежментийн чанарын сертификатуудаар батлагдах бөгөөд, энэ нь манай оюутнууд Европын түвшинд боловсрол эзэмшдэгийг гэрчилж байгаа юм.



2014 оноос менежментийн салбарын бакалавр, магистрын бэлтгэл нь олон улсын аттестатчилалын дагуу явагдаж байгаа. Төгсөгчид нь улсын хэмжээний диплом авах ба энэ нь хөдөө аж ахуй газар тариалангийн салбарын төрийн болон бизнесийн байгууллагуудын ажил олгогчдод бүрэн хүлээн зөвшөөрөгддөг. Мөн дипломонд хавсралтаар Европын стандартын сертификат олгогддог.

Красноярскийн хөдөө аж ахуйн улсын их сургууль нь ЕБДС төгсөгчдийг Сибирийн төв болох Красноярск хотод дээд болон дунд мэргэжлийн боловсрол эзэмшихийг урьж байна. Сургалтын төлбөр нь эзэмших мэргэжлээс шалтгаалах бөгөөд, өдрөөр суралцвал 679 – 1593, эчнээгээр суралцвал 329 – 679 ам.доллар байдаг. Бүх оюутнууд нь сургуульдаа ойрхон оюутны байрандаа байрлах боломжтой.



ЭЛСЭЛТИЙН КОМИССЫН ХОЛБОГДОХ ХАЯГ:

ОХУ, Красноярск хот, Елена Стасовагийн гудамж, 44 байр
Утас: +7 391 227 30 09;

+7 391 247 21 35.

E-mail: priem@kgau.ru;

agropriem@kgau.ru

Вэбсайт: www.kgau.ru


(монгол хэл дээрх мэдээлэл
Монгол гэсэн хэсэгт байгаа)



М.К.АММОСОВЫН НЭРЭМЖИТ ЗҮҮН ХОЙД БҮСИЙН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ



СЕВЕРО-ВОСТОЧНЫЙ ФЕДЕРАЛЬНЫЙ
УНИВЕРСИТЕТ ИМЕНИ М.К. АММОСОВА



М.К.Аммосовын нэрэмжит зүүн хойд бүсийн улсын их сургууль нь ОХУ-ын тэргүүлэх их сургуулиудын нэгэнд тооцогддог бөгөөд Холбооны хэмжээний 10 сургуулиудын 1-д, Оросын их дээд сургуулиудын үндэсний рейтингэд (интерфакс) 32-р байранд, Global World Communicator судалгаагаар дэлхийн шилдэг ТОП-500 их дээд сургуулиудын нэгд, QS Rankings – BRICS-ын ТОП-200-д тус тус ордог.

Индонез, Вьетнам, Украин, Афганистан, Перу, Гайана зэрэг улсуудаас мөн байдаг.

Оюутнууд “Эмчилгээ”, “Шүдний эмнэл зүй”, “Дэлхийн эдийн засаг”, “Менежмент”, “Хууль зүй”, “Барилга”, “Нефть газ”, “Уул уурхай”, “Хавсарга Геолог”, “Хавсарга Математик мэдээлэл зүй”, “Химийн технологи”, “Гадаад бүс нутаг судлал”, “Сэтгүүл зүй”, “Аялал жуулчлал”, “Биологи”,

гэсэн зарчмаар холимог байдлаар байрладаг. Их сургуульд спорт цогцолбор, стадион, бассейн, цанын бааз, 20 төрлийн спорт секцүүд, соёлын төв, 20 урлаг уран сайхны дугуйлангууд байдаг. Гадаад оюутнуудтай нэг бүрчлэн харилцах, байнгын дэмжлэг үзүүлэх зарчим дээр ажилладаг. “NEFU International” хэмээх оюутны клуб нь гадаад оюутны Якутск хотод дасан зохицох, сонирхолтой үйлчилгээ үзүүлэх, соёлын арга хэмжээ, хамт олны амралт зугаалга зохион байгуулах зэрэг үйлчилгээ үзүүлдэг.

Мөн тус их сургуульд Мамонтын музей байдаг бөгөөд оюутнууд уур амьсгалын өөрчлөлт, мөнхийн хүйтнийг судлан, якут алмас эрдэнэсээр бриллиантан эдлэл хийхийг сурахаас гадна энд өөрийн шинжлэх ухааны лаборатори, шүдний эмнэлэг бүхий орчин үеийн эмнэлэг болон өөр олон зүйл байдаг. Нэмэлт мэдээлэл: Оюутны дотуур байрны төлбөр: улсын тэтгэлгээр сурч байгаа оюутнуудад – 2, 3 өрөөтэй байр – 1 сард 550 рубль. Гэрээгээр сурч буй оюутнуудад – 1 сард 1100 рубль. Эрүүл мэндийн даатгалын төлбөр: 1 жилд 4900 рубль. Олон удаагийн сургалтын виз бүрдүүлэх/ жил бүрийн сунгалт: УФМС улсын татвар - 1600 рубль. Якутск хот дахь оюутны амьдралын дундаж өртөг: сард 15000-20000 рубль.



Энэ нь ОХУ-ын зүүн хойд бүсийн хамгийн том сургууль бөгөөд үүнд Оросын бүхий л мужуудаас 20000 оюутан суралцахаас гадна Хятад, Монгол, БНСУ, Тажикистан, Киргизстан,

“Клиник психологи” зэрэг боловсролын хөтөлбөрүүдийг илүүтэй сонгон суралцдаг.

Кампус нь тохилог, шинэ оюутны дотуур байртай. Бүх өрөөнүүд орос – гадаад оюутан

ХОЛБОГДОХ ХАЯГ:

ОХУ, Якутск хот,
Белинского 58 гуд.

Утас: +7 (4112) 36-14-53;
+7 (4112) 32-14-81

E-mail: international@s-vfu.ru

Вэбсайт: www.s-vfu.ru



ОРОСЫН
БОЛОВСРОЛЫН
ҮЗЭСГЭЛЭН
EXPO 2016



Уральский
федеральный
университет

имени первого Президента
России Б.Н. Ельцина



ОРОСЫН АНХНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ Б.Н.ЕЛЬЦИНЫ НЭРЭМЖИТ УРАЛЫН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Уралын улсын их сургууль нь Уралын эртний их сургуулиуд болох УГТУ-УПИ болон УрГУ-ийн суурин дээр байгуулагдсан. УУИС-д олон талт боловсролын зарчим үйлчилдэг бөгөөд үүнд техник, байгалийн шинжлэх ухаан, хүмүүнлэгийн бүхий л салбаруудыг хамран шинжлэх ухаан, боловсрол, нийгмийн хандлага, инноваци нэвтрүүлэлтийн төв нь болоод байна.

Тус их сургууль нь өнөөдөр дээд боловсролын өргөн хэмжээний хөтөлбөр, олон тооны тэтгэлгийн хөтөлбөрүүд хэрэгжүүлж (2016 онд 7000 гаруйд хүрнэ), үүндээ мөн гадаад оюутнуудыг хамруулж байна. "Эксперт РА" рейтингийн агентлагийн Оросын их дээд сургуулиудын нэр хүндийн судалгаагаар УУИС нь шилдэг 10 их сургуулийн тоонд орж, техникийн болон эдийн засгийн чиглэлийн боловсон хүчин бэлтгэх талаараа Оросын улсын сургуулиудаас манлайлж байна. УУИС нь мөн "Интерфакс" групп, "Эхо Москвы" радиостанцийн рейтингээр топ-15-д орж, QS World University Rankings рейтингийн топ-650, QS: Хөгжиж буй Европ болон Төв Азийн шинэ рейтингэд топ-60-д, QS World University Rankings: BRICS-ын орнуудын их сургуулиудаас 77-р байр, дэлхийн их сургуулиудын шанхайн Академик рейтингэд 500+ (The Academic Ranking of World Universities) байруудад тус тус ороод байна.

УУИС нь чанартай тоног төхөөрөмж, материаллаг баазтай. Сүүлийн хэдэн жилүүдэд их сургууль нь шинжлэх ухааны паркаа шинэчлэхэд үлэмж хэмжээний хөрөнгө оруулалт хийж, одоо энд дэлхийн түвшний судалгаа явуулж, тэтгэлэг авч, олон улсын шинжлэх ухааны хамтын ажиллагааг хэрэгжүүлэх боломж бий болоод байна. Одоогийн байдлаар их сургуульд 80 инновацийн аж ахуйн

нэгж, 72 дэвшилтэт технологийн төвүүд байгуулагдаад байна.

УУИС нь гадаад харилацаагаа улам өргөжүүлэн өнөөгийн байдлаар 400 гадаадын их сургуулиудтай хамтран ажиллаж олон улсын сүлжээний БРИКС-ийн их сургуулиудын Лиг, ТУХН орнуудын их сургуулиуд, ШХАБ-ын их сургуулиуд, Арктикийн их сургуулиуд, Орос, Хятадын техникийн их сургуулиудын холбоо зэрэг төслүүдэд оролцож байна.

УУИС-д сурна гэдэг бол) дэлхийн бүхий л орнуудын оюутнуудтай танилцах, урилгаар ирсэн гадаадын профессоруудын шилдэг лекц, семинаруудад суух, сургууль дээр жил бүр зохион байгуулагддаг олон улсын арга хэмжээнүүдэд оролцох боломж юм. Гадаадын эрдэмтэдийн энд ирдэг бас нэг шалтгаан нь тэд өндөр стандартад нийцсэн орчин үеийн техник төхөөрөмжүүд дээр ажиллах боломж байгаа юм.

Их сургуулийн оюутнууд өнөөдөр ОХУ-ын Ерөнхийлөгчийн, ОХУ-ын Засгийн газрын, Оросын анхны Ерөнхийлөгч Б.Н.Ельцины, В.Потанины буяны сан, Свердловск мужийн Амбан захирагчийн, Орос-Оксфордын сангийн зэрэг 20 гаруй төрлийн нэрийн тэтгэлэг авч байна.

Өнөөдөр уралын шилдэг их сургуульд 35000 гаруй оюутан суралцаж байгаагаас 24000 нь өдрөөр суралцаж байна. УУИС нь 177 дээд боловсролын мэргэжлийн чиглэл, 7 чиглэлээр дунд мэргэжлийн боловсрол, мөн ур чадвараа

УУИС-ын сургалтыг 3697 багш хариуцаж, үүнээс 570 доктор профессор, 1793 нь докторант, доцент байна. Их сургуулийн албан хаагчдаас Оросын шинжлэх ухааны академийн 24 жинхэнэ гишүүн, сурвалжлагч-гишүүн, Оросын зураачдын академийн 2 гишүүн, Оросын болон олон улсын академуудын 110 гишүүд байдаг.

нэмэгдүүлэх нэмэлт боловсролын хөтөлбөрүүд, мэргэжлийн дахин бэлтгэл, их сургуулийн элсэлтийн бэлтгэл, MBA-ийн ур чадварын сургалтыг тус тус зохион байгуулж байна.

Их сургуулийн бүтцэд 18 институт (үүнд газрууд болон факультетууд багтдаг), 250 гаруй тэнхим, 14 салбар ордог. УУИС-ийн оюутнууд нь 14 сургалтын байруудад сурч, 16 оюутны байруудад амьдарч байна. 2013 оны 12 сард 1000 хүнд зорилсан шинэ дотуур байр ашиглалтанд орсон. Өнөөдрийн байдлаар оюутнуудыг хүлээж авах 6500 орчим хүний байр байна.

Тус их сургуульд дэлхийн 75 орноос 1700 гаруй гадаадын оюутан байгаагаас мөн Монголоос суралцаж байна. Түүнээс гадна их сургууль нь жил бүр 200-с багагүй оюутныг академик солилцоо, олон улсын сургуулиудын хөтөлбөрүүдэд хамруулдаг. Жил бүр УУИС-ийн 500 багш, оюутнууд гадаад руу академик солилцооны хөтөлбөрт хамрагдан их сургуулиас тэтгэлэг авах боломжтой байдаг.

ХОЛБОГДОХ ХАЯГ:

www.urfu.ru

УУИС-ийн элсэлтийн комисс

e-mail: priem@urfu.ru

+7 (343) 375-44-74

Екатеринбург хот, 620002,

Энх тайвны гуд., 19, каб. ГУК-100



СИБИРИЙН ХАРИЛЦАА ХОЛБОО МЭДЭЭЛЭЛ ЗҮЙН УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН САЛБАР

БУРИАДЫН МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ИХ СУРГУУЛЬ

Сибирийн харилцаа холбоо, мэдээлэл зүйн улсын их сургуулийн (СХХМЗУИС) салбар Буриадын мэдээлэл харилцаа холбооны их сургууль нь Буриадын нийслэл Улаан-Үд хотноо Монголын хилээс 150 км-т оршдог бөгөөд эрчимтэй хөгжиж байгаа орчин үеийн мэдээлэл харилцаа холбооны салбарт 2 факультетдаа Холбоо, Мэдээллийн технолог болон эдийн засгийн мэргэжлүүдээр тус тус сургаж байна.

Уг их сургууль нь 2 түвшний бэлтгэлийг (дээд боловсрол болон дунд мэргэжлийн боловсрол) дараахь чиглэлүүдээр олгож байна. Үүнд: Мэдээлэл харилцаа холбооны технолог болон холбооны систем, Мэдээлэл зүй болон тооцоолон бодох техник, Эдийн засаг, Бизнес-мэдээлэл зүй, Менежмент, Шуудан холбоо зэргээр бэлтгэж байна.

Өнөөдөр БМХХИС-ийн төгсөгчид харилцаа холбоо, IT технологийн салбарт зөвхөн Буриадаар зогсохгүй Москвагаас эхлээд гадаадад хүртэл амжилттай ажиллаж, карьераа ахиулж байна. БМХХИС-ийн багш нарын хамт олон нь үргэлж мэргэжилтнүүдээ бэлтгэх түвшнээ нэмэгдүүлж, шинэ шинэ эрэлт хэрэгцээтэй мэргэжлүүдийг нээж байна.

БМХХИС нь орчин үеийн шинжлэх ухаан-арга зүйн материал техникийн баазаар бүрэн хангагдсан. Их сургууль нь СОРАН-ы Буриад дахь шинжлэх ухааны төв болон улсынхаа шилдэг харилцаа холбооны компани, IT зах зээлийн оролцогчидтой хамтран ажилладаг.

БМХХИС бол сонирхолтой оюутны амьдрал, эрэлт хэрэгцээтэй мэргэжил, тогтвортой ирээдүй юм. Их сургуулийн боловсролын бүхий л үйл явц нь оюутнууд бүрэн хэмжээнд оюуны болоод шинжлэх



ухааны амьдралдаа дасан зохицох орчныг бүрдүүлсэн байдаг. Байгалийн бүс нутагт цорын ганц нарийн мэргэжлийн их сургуулийн хувьд материал техникийн баялаг баазтай бөгөөд орчин үеийн лаборатори, компьютерийн анги, спорт заал, сургалтын байр болон оюутны байран дахь интернет бүрэн хангагдсан байдаг.

400 хүний дотуур байр нь сургалтын орчиндоо байдаг бөгөөд гадаад дотоодын оюутнуудыг амралтын өрөө, бүрэн тоноглогдсон гал тогоо, бэлтгэх өрөө, спорт танхим, цайны газар, эрүүл мэндийн төв, бүжгийн танхим, угаалгын өрөө бүхий тохилго орчныг бүрдүүлэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн амьдрах нөхцөлөөр хангаж байна.

Их сургуулийн оюутнууд нь олон улсын, бүсийн, улсын, хотын олимпиад, эрдэм шинжилгээний хурал, уралдаануудад өндөр амжилт үзүүлдэг.

БМХХИС-т шаардлагыг хангасан нийгэм-соёлын орчныг бүрдүүлсэн бөгөөд, үүний ачаар оюутнууд өөрсдийгөө спорт, театр, дуу, бүжиг зэргээр хөгжүүлэх боломжтой. Их сургуулийн нэг чухал бахархал бол төрөл бүрийн түвшний уралдаан спартакиадуудын хөнгөн атлетик, волейбол, барилдааны тамирчид юм.

Сургалтын төлбөр нь эзэмших мэргэжлээс шалтгаалах бөгөөд өдрөөр суралцахаар бол 352-648 ам.доллар, эчнээгээр бол 254-423 ам.доллар байдаг. Бүх оюутнууд дотуур байраар хангагдана.



ХОЛБОГДОХ ХАЯГ:

ОХУ, Улаан-Үүд хот, Трубочеевын гуд., 152
Утас: +7 3012 240024; +7 9021690100.
E-mail: bfsibguti@mail.ru
Вэбсайт: www.bfsibguti.ru



ТОМСКИЙН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ


Томскийн улсын их сургуулийг анх II Александр Император 1878 оын 5 сарын 28-нд байгуулж, тухайн үедээ Орос Улсын ази дахь анхны дээд боловсролын байгууллага болсон юм. Өнөөдөр ТУИС бол дэлхийд данстай, оросын боловсролын лидеруудын нэг болсон.

ТУИС нь улсынхаа томоохон сонгодог их сургуулиудын нэгэнд зүй ёсоор тооцогдож түүний бүрэлдэхүүнд 23 факультет, 4 сургалтын институт, Новосибирск хотод салбар, 38 дээд сургуулийн өмнөх бэлтгэл, Сибирийн хотууд болон Казахстан дахь бэлтгэл сургуулиуд ордог. ТУИС нь 135 мэргэжлийн чиглэлээр сургалтаа явуулж ОХУ-ын ТОП-15 сургуульд багтдаг. Үүний зэрэгцээ ТУИС нь БРИКС-ын орнуудын их сургуулиудын рейтингэд 47-рт жагсан, QS-ийн рейтингээр дэлхийн 500 шилдэг их сургуулиудын тоонд ордог.

Одоогоор тус их сургуульд ойролцоогоор 10-аад олон улсын хөтөлбөрүүд хэрэгжиж байгаагаас, суралцаж төгссөний дараа оюутнуудад ТУИС болон түнш сургуулийн 2 диплом олгогддог.



2016 оны 9 сараас дараахь чиглэлүүдээр англи хэл дээр сургалт явагдах боломж бүрдэж байна: Linguistics, Fundamental Computer Science and IT; магистратура - Physics methods and informational technologies in biomedicine (Double degree), Mathematical analysis and modeling, Studies of the European Union, Professionally oriented translation, Data mining and bioinformatics, Applied computer science in the sphere of information, Finance, Mathematics methods, data analysis and processing in economics, Chemistry, Ecological management, Management (НОЦ Экономика и



управления), Information technologies in science and instrument engineering.

ТУИС-ийн суралцагчид магистрт үргэлжлүүлэн суралцах боломжтой бөгөөд 170 гаруй магистрын хөтөлбөрүүдийн сонголт бий.

ТУИС-ийн ажилтан, оюутан, аспирантуудын хувьд баялаг нөөцтэй бөгөөд үүнд 4 сая гаруй ном бүхий Шинжлэх ухааны номын сан байдаг. Үүнээс гадна хэрэглэгчдэд 50-60 сүлжээний баазууд дахь номуудыг ашиглах боломж байдаг.

Үүнээс гадна ТУИС нь ОХУ-ын боловсролын салбарын тэргүүн эгнээнд байгаад зогсохгүй мөн улсынхаа шинжлэх ухаан судалгааны хамгийн том төвд тооцогддог. Эрдэмтэдийн судалгааны цар хүрээ өргөн ба үүнд цөмийн физикээс эхлээд нийгмийн робот техник болоод сансар судлалыг хамарч байна.

ТУИС-д элсэн орсон гадаадын оюутнууд замын зардал болон дотуур байранд амьдрах, сургалтын төлбөр зэрэг тусгай тэтгэлэг авах боломж байдаг. Харин өдрөөр суралцахаар элссэн бусад хотуудын оюутнуудад чийрэгжүүлэх танхим, хичээлийн болон

амралтын танхим, кафе бүхий “Парус” оюутны байранд амьдрах эрх олгодог.

ХОЛБОГДОХ ХАЯГ:

ТУИС-ийн гадаад харилцааны газар
ОХУ, Томск 634050, Төв байр, Ленины 36 өргөн
чөлөө, 3 давхар, 326-327 тоот
Утас: +7 (3822) 529558
E-mail: int.admissions@mail.tsu.ru
Вэбсайт: www.tsu.ru

ТОМСКИЙН БАРИЛГА АРХИТЕКТУРЫН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ



Томскийн барилга архитектурын их сургууль нь Сибирийн нэн эртний хот болох Томскд 1952 онд байгуулагдсан. Өнөөдрийг хүртэл ТБАИС нь дээд зэргийн шинжлэх ухаанд суурилсан орчин үеийн боловсролын байгууллага болтлоо хөгжиж, бакалавраас шинжлэх ухааны доктор хүртэлх мэргэжилтнүүдийг бэлтгэж байна. Сургалт, эрдэм шинжилгээ, практикт тулгуурлан уран барилга, барилгын боловсрол, шинжлэх ухааны шилдэг уламжлалыг хөгжүүлэх нь их сургуулийн эрхэм зорилго юм.

Их сургуулийн эрдэм шинжилгээний ажлууд 5 чиглэлээр хэрэгжиж байна. Үүнд: барилгын бүтэц, барилга байгууламжийн тооцооны онол, барилгын ажлын механикжуулалт, автоматжуулалтын аргууд, уран барилга, автомашин болон уран барилгын өвийг сэргээн засварлах.



Их сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгасан мэргэжлүүд: уран барилгын зураг, зураг төслийн ажил, барилга байгууламж, зам гүүр, газрын тос хийн хоолой барих төслүүдийн эдийн засгийн үндэслэлтэй боловсруулах, барилгын инженер техник хангамж, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй технологийн аюулгүй аргуудыг ашиглах зэрэг барилгын салбарын бүхий л мэргэжлээр сонгон суралцаж болно.

62 жилийн түүхтэй тус их сургууль нь одоогоор 56000 гаруй мэргэжилтэн бэлтгэн төгсгөөд байна. Өнөөдрийн хувьд ТБАИС-д 8000 гаруй оюутан өдрөөр болон эцнээгээр суралцаж байна. Тус

их сургуульд бакалаврын 28, магистрын 18, мэргэжилтэн бэлтгэх 3, аспирантурын 4, мэргэжлийн дунд боловсролын 6 гэсэн хөтөлбөрүүдээр тус тус суралцуулж байна. Сургууль нь 38 танхимтай,

ТА БҮХНИЙГ ТОМСКИЙН БАРИЛГА АРХИТЕКТУРЫН ИХ СУРГУУЛЬД СУРАЛЦАХЫГ УРЬЖ БАЙНА!

500 гаруй багш, ажилтан байгаагаас 51 профессор, 67 шинжлэх ухааны доктор, 238 дээд эрдэмтэн, 100 гаруй доцент ажиллаж байна. Бакалавр, магистр аспирантур гээд бух хичээлүүд орос хэл дээр явагддаг. Гадаадын оюутнуудад зориулан 2014 оноос орос хэлний бэлтгэл анги нээгдэн ажиллаж байна.

ХОЛБОГДОХ ХАЯГ:

Хаяг: 634003, Томская обл.,
г. Томск, пл. Соляная, 2.
Утас: +7-3822-653693, (3822)
701019
E-mail: pk@tsuab.ru
Вэбсайт: www.tsuab.ru



ЭРХҮҮГИЙН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Эрхүүгийн улсын их сургууль нь байгалийн шинжлэх ухааны, физик-математикийн, хүмүүнлэгийн, нийгэм-эдийн засгийн, багшийн болон шинжлэх ухааны чиглэлүүдийг өргөн хүрээнд хамарсан сонгодог чиглэлийн их сургууль юм. ЭУИС-ийн өрсөлдөх давуу тал болон бүс нутгийн гайхамшигт онцлог (ЮНЭСКО-ийн дэлхийн өвд бүртгэлтэй) нь Оросын болон олон улсын боловсрол шинжлэх ухааны салбарт оюуны бөгөөд инновацийн хувьд өөрийгөө идэвхитэй сурталчлах боломжийг олгодог.

ЭУИС бол Дорнод Сибирь болон Алс Дорнодын 1918 онд 600 оюутан 3 факультеттайгаар эхлэж байсан хамгийн эртний их сургууль юм.

Сургалтын болон эрдэм шинжилгээ судалгааны ажлуудыг Уралаас гадна хамгийн том Бүсийн шинжлэх ухааны номын санд (1918 онд байгуулагдсан) хийж болдог. Энэ нь 3 сая гаруй нэгж, 20000 ховор номтойгоос гадна олон улсын орчин үеийн компьютерийн сүлжээтэй холбогдож хотын болон бүсийн хэмжээнд үйлчилгээ үзүүлдэг.

1990 оноос өмнө зөвхөн Монгол Улсын их сургууль, Чехийн Карловын их сургуультай хамтын ажиллагааны 2 гэрээтэй байсан бол, 1990 оноос олон улсын харилцааны хөгжил эрчимтэй явагдаж өнөөдрийн байдлаар ЭУИС нь 33 гадаадын түнш болон бусад сургалтын байгууллагуудтай нягт хамтран ажиллаж байна. Тус их сургуулийн нэгжүүд нь олон улсын хамтын ажиллагааны хүрээнд жил бүр эрдэм шинжилгээний хурал, төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд ирж буй, эрдэм шинжилгээ судалгааны зорилготой, орос хэл болон зуны сургалтанд хамрагдах хүсэлтэй зэрэг 200 гаруй гадаадын иргэдийг хүлээж авдаг. Их сургуульд Хятад, Монгол, БНСУ, АНУ, Бельги,

Франц, Ирак, Австри, Их Британи болон ТУХН-ийн 300-аад гадаад

Өнөөдрийн ЭУИС – энэ бол 13000 гаруй оюутан, 6 боловсролын институт, 18 факультет, Братск дахь салбар, 160 доктор бүхий 850 багш, 450 докторант, 100000-аад төгсөгчид юм.

оюутан суралцдаг.

Их сургуульд 2 диплом олгодог 12 хөтөлбөр байдаг. Хамгийн олонд танигдсан хөтөлбөрүүд нь Мэрилэндийн их сургуулийн коллежтай (АНУ) хамтарсан сибирь-америкийн факультет, орос-австралийн хөтөлбөр (Өмнөд Квинслэндын их сургуультай хамтарсан) мөн Ляонины их сургуультай (БНХАУ, Шэньян хот) хамтарсан олон улсын эдийн засаг, хэл шинжлэлийн их сургууль юм. 2014 оноос Киль хотын их сургуультай хамтарсан (Герман) улсдаа цорын ганцад тооцогдох



экологийн менежментийн чиглэлээр оюутнуудаа төлбөргүй сурах магистрын хөтөлбөр үйл ажиллагаагаа эхэлсэн. 2013-2015 онуудад Савойи (Франц), Познани (Польш)-ийн их сургуулиудтай хамтарсан 2 дипломын шинэ хөтөлбөрүүд эхлээд байгаа.

ЭУИС нь бүс нутагтаа цорын ганц Оксфорд-Россия сангийн тэтгэлэгт хөтөлбөрийн оролцогч их сургууль юм.

ЭУИС нь олон улсын болон Оросын рейтингэд өөрийн байр сууриа нэмэгдүүлээд байна. Үүнд: анх удаагаа (Эрхүүгийн их сургуулиуд дундаас ганцаараа) 141-150 байраар БРИКС-ын орнуудын топ-200 сургуулийн жагсаалтад орсон. 2015 онд ЭУИС нь 10 байраар ахиулан Оросын нэртэй их сургуулиудыг ардаа орхисон юм. 2015 оны 7 сард дэлхийд алдартай Webometrics-ийн рейтингээр Оросын топ-25 их сургуулийн 22-р байранд орсон.

ХОЛБОГДОХ ХАЯГ:

Хаяг: 664003 Иркутск муж, Иркутск хот, Карла Марксын гуд., 1

Элсэлтийн төв комиссын утас: (3952) 521-555, 243-416
E-mail: zpk@isu.ru
Вэбсайт: www.isu.ru



ИРКУТСКИЙ
НАЦИОНАЛЬНЫЙ
ИССЛЕДОВАТЕЛЬСКИЙ
ТЕХНИЧЕСКИЙ УНИВЕРСИТЕТ

ЭРХҮҮГИЙН ҮНДЭСНИЙ СУДАЛГААНЫ ТЕХНИКИЙН ИХ СУРГУУЛЬ

Эрхүүгийн үндэсний судалгааны техникийн их сургууль бол ОХУ-ын өнцөг бүрээс болон дэлхийн 27 орноос (1300 гаруй гадаад оюутан) 20000 гаруй оюутнууд суралцаж байгаа эвсэг гэр бүл юм.

2010 онд “үндэсний судалгааны их сургууль” гэсэн статустай болсон. ОХУ-д нийтдээ 29 их сургууль л ийм зэрэглэлтэй байдаг. “Үндэсний судалгааны их сургууль”-ийн хөтөлбөр нь тус сургуульд дэлхийн түвшний орчин үеийн судалгаа шинжилгээ, лабораторийн тоног төхөөрөмжтэй болох, багш, аспирантууд, оюутнуудаа гадаад орнуудад дадлагаар явуулах боломжийг олгосон. Их сургуульд 1 тэрбум рублийн үнэтэй 50 эрдэм шинжилгээ-судалгааны лаборатори байгуулагдсан.

Оюутнуудад олон улсын түвшний боловсрол эзэмших бодитой боломж байдаг. Өнөөдрийн байдлаар тус сургууль нь Франц, Герман, Их Британи, Чех, Япон, БНХАУ, мөн Монгол Улсын Боловсролын их сургууль, Шинжлэх ухаан техникийн их сургуулиуд гээд дэлхийн 19 орны их сургуулиудтай хамтран ажиллаж, 130 гаруй хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээр байгуулаад байна.

9000 орчим гадаад оюутнууд ЭУСТИС-ийн бэлтгэл ангийн сургалтанд хамрагдсан байдаг бөгөөд 50 гаруй жилийн хугацаанд гадаадын 1500 гаруй мэргэжилтэн бэлтгэж, үүнээс Монголын сонсогч, оюутан, төгсөгчид ихээхэн хувийг эзэлдэг.



Мөн их сургууль нь хамгийн орчин үеийн спортын цогцолбортой. Үүнд: 37 спорт заал, бүх төрлийн спортоор хичээллэх талбай, бүрэн тоноглогдсон олон улсын түвшний хөнгөн атликийн стадион зэрэг байдаг. ЭУСТИС-ийн спорт клубын дэргэд 37 секц дугуйлан хичээллэдэг бөгөөд их сургуулийн олон тамирчид ОХУ-ын шигшээ багуудын бүрэлдэхүүнд ордог.

Харин дуу, бужиг, театр, фото зураг, КВН тоглох зэрэг уран бүтээл туурьвих хүсэлтэй оюутнуудыг соёл-хүмүүжлийн хамт олонч Төв нь дуртайя хамт олондоо элсүүлдэг. ЭУСТИС-ийн уран бүтээлчид гадаад улс орнуудад ч бас танигдсан байдаг.

Оюутны хотхон нь 16 дотуур байр, оюутны хоолны газрууд, дэлгүүр, аптека, кафе болон спорт цогцолборуудтай. Өнөөдрийн байдлаар их сургуулийн дотуур байруудад 4000 гаруй оюутнууд амьдарч байна.

Та бүхнийг Эрхүүгийн үндэсний судалгааны техникийн их сургуульдаа хүлээн авахдаа бид баяртай байх болно.

**Мэргэжлийн
карьераа
амжилттай
эхлэх нь их
дээд сургуулиа
сонгохоос
эхэлдэг.**

ХОЛБОГДОХ ХАЯГ:

Web-site: www.istu.edu | Хаяг: 664074, Иркутск хот, 4-Железнодорожная гуд., 159. Гадаад (бэлтгэл) факультет, 309, 312.

Гадаад (бэлтгэл)
факультетын Декан:
*Ефремов Виталий
Викторович*
Утас: +7 (3952) 405-622,
e-mail: mpf1@istu.edu

Их сургуулийн өмнөх
бэлтгэл ангийн элсэгчдэд:
Ербаева Инга Дамбаевна
Утас: +7 (3952) 405482,
e-mail: mpf1@istu.edu;

Дунд болон дээд
боловсролын хөтөлбөрийн
элсэгчдэд:
*Тулаева Яна Ивановна,
Макаренко Оксана
Сергеевна*
Утас: +7 (3952) 405-624,
+7 (3952) 405-625,
e-mail: mpf1@istu.edu;

Эрдмийн зэргийн
боловсон хүчнийг бэлтгэх
хөтөлбөрийн элсэгчдэд:
*Чечеткина Лариса
Петровна*
Утас: +7 (3952) 405215,
e-mail: chech@istu.edu.

**График презентаций вузов-участников "Российской образовательной выставки-2016"
"Оросын боловсролын үзэсгэлэн-2016"-ийн оролцогч их сургуулиудын
танилцуулга хийх цагийн хуваарь**

№	Названия организаций, вузов Их сургуулиуд, байгууллагуудын нэрс	Время Цаг		
		17.03.2016	18.03.2016	19.03.2016 по мере необходимости
1	Российский центр науки и культуры в Улаанбаатаре Презентация о Порядке приема монгольских граждан в вузы России в 2016/2017 учебном году Улаанбаатар дахь Оросын шинжлэх ухаан соёлын төв 2016/2017 оны хичээлийн жилд ОХУ-ын их дээд сургуулиудад монголын иргэдийг элсүүлэх журмын талаар танилцуулга	16:00-16:30	10:00-17:00 работа регистрационной комиссии	10:00-16:00 работа регистрационной комиссии
2	Российский экономический университет им.Г.В.Плеханова	16:30-16:50		09:00-09:15
3	Томский государственный архитектурно-строительный университет	16:50-17:10		09:15-09:30
4	Иркутский государственный университет	17:10-17:30		09:30-09:45
5	Иркутский национальный исследовательский технический университет	17:30-17:50		09:45-10:00
6	Владивостокский государственный университет экономики и сервиса	17:50-18:10		10:00-10:15
7	Томский государственный университет	18:10-18:30		10:15-10:30
8	Кемеровский технологический институт пищевой промышленности		14:00-14:20	10:30-10:45
9	Белгородский государственный аграрный университет имени В.Я.Горина		14:20-14:40	10:45-11:00
10	Северо-Восточный федеральный университет им.М.К.Аммосова		14:40-15:00	11:00-11:15
11	Красноярский государственный аграрный университет		15:00-15:20	11:15-11:30
12	Российский государственный университет нефти и газа им. И.М.Губкина		15:20-15:40	11:30-11:45
13	Уральский Федеральный университет имени первого Президента России Б.Н.Ельцина		15:40-16:00	11:45-12:00
14	"Бурятский институт инфокоммуникаций (филиал) «Сибирского государственного университета телекоммуникаций и информатики		16:00-16:20	12:00-12:15

**"ОРОСЫН БОЛОВСРОЛЫН ҮЗЭСГЭЛЭН
EXPO-2016"-ИЙН ХӨТӨЛБӨР**

2016 оны 3 сарын 19

Бямба
09⁰⁰-13⁰⁰

2016 оны 3 сарын 17	Пүрэв 09 ⁰⁰ -19 ⁰⁰	2016 оны 3 сарын 18	Баасан 09 ⁰⁰ -19 ⁰⁰	09 ⁰⁰ -13 ⁰⁰ Үзэсгэлэн үзэгчдийн бүртгэл, үзэсгэлэнгийн үйл ажиллагаа
09 ⁰⁰ -10 ⁰⁰ Үзэсгэлэнд оролцогчдын бүртгэл	11 ⁰⁰ -19 ⁰⁰ Үзэсгэлэн үзэгчдийн бүртгэл, үзэсгэлэнгийн үйл ажиллагаа	09 ⁰⁰ -19 ⁰⁰ Үзэсгэлэн үзэгчдийн бүртгэл, үзэсгэлэнгийн үйл ажиллагаа	11 ³⁰ -12 ³⁰ Сугалааны тохирол	09 ⁰⁰ -12 ¹⁵ Их дээд сургуулиудын танилцуулга, презентаци (цагийн хуваарийн дагуу)
11 ⁰⁰ -11 ³⁰ Хэвлэлийн бага хурал	12 ³⁰ -14 ⁴⁵ Өдрийн хоол "Батько Опанас" ресторанд (оролцогчид)	13 ⁰⁰ -15 ⁰⁰ Өдрийн хоол "Батько Опанас" ресторанд (оролцогчид)	14 ⁰⁰ -16 ²⁰ Их дээд сургуулиудын танилцуулга, презентаци (цагийн хуваарийн дагуу)	09 ⁰⁰ -12 ⁰⁰ Оросод төгсөгчдийн уулзалт (хүсэлтээр)
15 ⁰⁰ -16 ⁰⁰ Үзэсгэлэнгийн албан ёсны нээлтийн ажиллагаа	16 ⁰⁰ -18 ³⁰ Их дээд сургуулиудын танилцуулга, презентаци (цагийн хуваарийн дагуу)	16 ⁰⁰ -19 ⁰⁰ "Цаг үеийн сурвалжлага"	16 ⁰⁰ -19 ⁰⁰ Оросод төгсөгчдийн уулзалт (хүсэлтээр)	10 ⁰⁰ -12 ⁰⁰ Тест шалгалт
16 ⁰⁰ -19 ⁰⁰ Оросод төгсөгчдийн уулзалт (хүсэлтээр)	16 ⁰⁰ -19 ⁰⁰ Тест, шалгалт	10 ⁰⁰ -19 ⁰⁰ Тест, шалгалт		12 ⁰⁰ -13 ⁰⁰ Үзэсгэлэнд оролцогчдын ОХУ-ын ЭСЯ-ны зөвлөх, Россотрудничество агентлагийн Монгол дахь төлөөлөгчийн газрын тэргүүн, Улаанбаатар дахь Оросын шинжлэх ухаан соёлын төвийн захирал Е.Г.Михайловтай хийх уулзалт
				13 ⁰⁰ Үзэсгэлэнгийн хаалт
				13 ³⁰ -15 ³⁰ Үзэсгэлэнгийн хүндэт зочид болон оролцогчдод зориулсан хаалтын Хүлээн авалт